



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/83

Хархорин сум

**Хэлний бодлогын салбар зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн  
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам" -ын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ нь:**

1. Хэлний бодлогын Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хархорин сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн "Хэлний бодлогын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай" А/167 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

